

ЧИНГИС ХААН ОЛОН УЛСЫН НИСЭХ ОНГОЦНЫ БУУДЛЫН АВТОМАШИНЫ ЗОГСООЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТАД ХИЙСЭН СУДАЛГААНЫ ТОЙМ

A REVIEW OF A RESEARCH ON THE LEGAL KNOWLEDGE OF TRAFFIC
POLICE OFFICERS

Эрдэнэбатын Анхбаяр

Дотоод хэргийн их сургуулийн магистрант, цагдаагийн ахлах дэслэгч

Pol. SR. Lt. Ankhbayar Erdenebat, MA Scholar, University of Internal Affairs

Балжиннямын Баянмөнх*

Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх зүйн
тэнхимийн профессор, доктор, дэд профессор, цагдаагийн дэд хурандаа

Pol. Lt. Col. Bayanmunkh Baljinnyam, Assoc. Prof, Ph.D, Professor, Department of
Police Law, Police School, University of Internal Affairs

*хариуцлагатай зохиогч: b.bayadaa2007@gmail.com

Хураангуй: Олон улсын нисэх онгоцны буудлын авто машины зогсоол нь зорчигчид, зочид, нисэхийн ажилтнууд, түр хугацааны зочид, такси, түрээсийн болон үйлчилгээний машинуудыг байрлуулах зориулалттай тусгай бүс юм. Эдгээр зогсоолууд нь зорчигчдын тав тух, нисэх буудлын аюулгүй байдал, автомашины замын хөдөлгөөний урсгал зохицуулалтыг хангах үүрэгтэй (Chapter 17.27: PARKING STANDARDS AND REQUIREMENTS, 2025).

Олон улсын нисэх онгоцны буудлын авто машины зогсоолын зохион байгуулалт, нөхцөл байдлыг судалснаар а) зогсоол руу орж, гарах чиглэл, замын тэмдэглэгээ тодорхой болж, саатал багасна; б) Түр болон урт хугацааны зогсоолын бүсийг зөв байршуулснаар хөдөлгөөний урсгал сайжирна; в) Аюулгүй байдал нэмэгдэж, явган зорчигчийн бүсийг тодорхой болж, тээврийн хэрэгслийн урсгалыг зөв чиглүүлэх боломж нэмэгдэх юм.

Энэхүү судалгааны тоймд “Чингис Хаан” олон улсын нисэх буудлын дэргэдэх авто машины зогсоолын замын хөдөлгөөний урсгал, чиглэл, зохион байгуулалт, түүний хэрэгжилт, зогсоолын ачаалал, замын хөдөлгөөний дүрмийн хэрэгжилт, гардаг зөрчлийн хэлбэр, нөлөөлж буй хүчин зүйл, зогсоолын зохион байгуулалтыг өөрчлөх хэрэгцээ шаардлага, сайжруулахтай холбоотой санаа бодлыг танин мэдэх зорилгоор Иргэний агаарын тээврийн 28 алба хаагчаас анкет асуулгын аргаар судалгаа авч, түүнийхээ үр дүнг шинжилснээ товч өгүүлсэн болно.

Abstract: The international airport parking lot is a special area intended for the parking of passengers, guests, aviation personnel, temporary visitors, taxis, rental and service vehicles. These stops are responsible for ensuring passenger comfort, airport security, and traffic flow.

By studying the organization and condition of the international airport parking lot, a) the directions to enter and exit the parking lot and road markings will be clear, reducing delays, b) traffic flow will be improved by properly positioning temporary and long-term parking areas, and c) safety will be increased, pedestrian areas will be clearly defined, and ways to properly direct vehicle flow will be found.



УИА-ийн
Хүснэгт 17.27



This research review briefly describes the survey conducted by 28 Civil Aviation Administration employees using questionnaires to identify the traffic flow, direction, organization, and implementation of parking lots at Chinggis Khaan International Airport, parking load, enforcement of traffic rules, types of violations, influencing factors, the need to change parking lot organization, and ideas related to improving parking lot organization.

Түлхүүр үгс: Олон улсын нисэх онгоц буудал, авто машины зогсоол, зогсоолын зохион байгуулалт, замын хөдөлгөөний урсгал, чиглэл.

Keywords: International airport, parking lot, parking arrangement, traffic flow and direction.

Удиртгал

Олон улсын нисэх онгоцны буудлын авто машины зогсоол нь зорчигчдын тав тух, нисэх буудлын үйл ажиллагааны хэвийн байдал, аюулгүй байдал, тээврийн зохицуулалтын чухал хэсэг юм.

Манай улсын хувьд олон улсын стандарт шаардлагад нийцсэн нисэх онгоцны ганцхан буудалтай бөгөөд энэ нь Хөшигийн хөндийн “Чингис хаан” олон улсын нисэх буудал юм. Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт, Улаанбаатар хотоос 50 гаруй километрийн зайд байрладаг “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудал нь Монгол Улс болон Япон Улсын Засгийн газруудын хамтын ажиллагааны хүрээнд баригдсан томоохон бүтээн байгуулалт бөгөөд 2021 оны 7 дугаар сарын 4-ний өдөр Улаанбаатар - Токио чиглэлд нислэг үйлдэж, үйл ажиллагаагаа албан ёсоор эхлүүлжээ (“Чингис хаан” олон улсын нисэх буудлын нээлтийн ёслол, 2021).

“Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудлын дэргэдэх авто машины зогсоолоор байнга үйлчлүүлдэг таксины компанийн жолооч болон хувиараа таксинд явдаг 7 жолооч иргэдтэй фокус ярилцлага хийсний үндсэн дээр энэ сэдвийг судлах шаардлага байгааг анх олж харсан байдаг. Тэгээд олон улсын нисэх буудлын дэргэдэх авто машины

зогсоолын зохион байгуулалт, нөхцөл байдлыг судлах хэрэгцээ шаардлагыг а) Нисэх буудлын зорчигчдын тоо өсөхийн хэрээр авто машины хөдөлгөөн ихэсдэг тул үүнтэй уялдан замын зохион байгуулалтыг сайжруулах тулгардаг, б) Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, түр болон удаан хугацааны зогсоолын байршил зохисгүй байх нь түгжрэл үүсэх нөхцөл болдог, в) авто машины зогсоолын хөдөлгөөнийг хянахгүй бол осол гарах магадлал нэмэгдэнэ, г) зогсоолын замын хөдөлгөөнийг зөв зохион байгуулах нь зорчигчдод ая тухтай үйлчлэх боломж бүрдүүлэх явдал гэж тодорхойлсон.

Харин өнөөдөр “Чингис Хаан” олон улсын нисэх буудлын дэргэдэх авто машины зогсоолын замын хөдөлгөөний зохион байгуулалт, өнөөгийн нөхцөл байдал, зогсоолын хүчин чадал, зогсоолын ачаалал, гардаг зөрчил, гарахад нөлөөлж буй хүчин зүйл, зогсоолын зохион байгуулалтыг өөрчлөх хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, сайжруулах арга замыг эрэлхийлэх шаардлага байгааг фокус ярилцлагыг үндэслэн, анкет асуулгын арга ашиглан энэхүү судалгааны ажлыг хийв.

“Чингис Хаан” олон улсын нисэх буудлын дэргэдэх авто машины зогсоолын зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт,

зогсоолын ачаалал, нөхцөл байдал, хүчин чадал, зогсоолын бүсэд гардаг зам тээврийн осол, зөрчил, гарахад нөлөөлж буй хүчин зүйл, зогсоолтой холбоотой алба хаагчдын санаа бодлыг танин мэдэх, сайжруулах арга замыг эрэлхийлэхэд энэхүү судалгааны ажлын зорилго оршино.

Энэхүү судалгааны ажлын зорилгыг хангах үүднээс дараах зорилтыг дэвшүүлсэн болно. Үүнд:

- Олон улсын нисэх буудлын дэргэдэх авто машины зогсоол, түүний хэрэгцээ шаардлага, ач холбогдлыг судалж үзэх;
- “Чингис Хаан” олон улсын нисэх буудлын дэргэдэх авто машины зогсоолын зохион байгуулалт, замын хөдөлгөөний урсгал, чиглэлийг судлах;
- Олон улсын нисэх буудлын дэргэдэх авто машины зогсоол, буудлын бүсэд гардаг зам тээврийн осол, зөрчлийн талаар алба хаагчдын санаа бодолд шинжилгээ хийх;
- “Чингис Хаан” олон улсын нисэх буудлын дэргэдэх авто машины зогсоолын зохион байгуулалт, замын хөдөлгөөний урсгал, чиглэл, түүний хэрэгжилтэд тулгарч байгаа хүндрэл бэрхшээлийг гаргаж ирэх;
- Олон улсын нисэх буудлын дэргэдэх авто машины зогсоолын зохион байгуулалтыг сайжруулах, замын хөдөлгөөний урсгал, чиглэлийг өөрчлөхөд чиглэгдсэн, үндэслэл бүхий санал боловсруулах зэрэг болно.

Бид энэхүү судалгааны ажлынхаа хамрах хүрээг Монгол Улсад ганцхан байдаг “Чингис хаан” олон улсын нисэх буудлын дэргэдэх авто машины зогсоолтой холбоотойгоор хийсэн судалгааны ажлаар тодорхойлж байна.

“Чингис Хаан” олон улсын нисэх буудлын дэргэдэх авто машины зогсоолын зохион байгуулалт, замын хөдөлгөөний урсгал, чиглэлийн үр нөлөөг судалгаагаар тодорхойлж, зохион байгуулалт, эрх зүйн зохицуулалтад тулгарч байгаа хүндрэл бэрхшээл, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг олох, зогсоолын зохион байгуулалтыг сайжруулах, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох үндэслэл бүхий санал боловсруулж, зохих алба, нэгжийн удирдлагад хүргэх явдал болно.

“Чингис Хаан” олон улсын нисэх буудлын дэргэдэх авто машины зогсоолын зохион байгуулалт, замын хөдөлгөөний урсгал, чиглэл, эрх зүйн зохицуулалтын чиглэлээр анх удаа судалгаа хийсэн нь энэхүү судалгааны ажлын шинэлэг талыг илэрхийлж байгаа бол, тулгамдаж буй асуудлыг судалгаагаар гаргаж, шийдвэрлэх арга замыг эрэлхийлсэн нь

Үндсэн хэсэг

Олон улсын нисэх буудлуудын авто машины зогсоолын үүсэл, хөгжил нь агаарын тээврийн салбарын өргөжилт, зорчигчдын хэрэгцээ шаардлагатай уялдан хувьсан өөрчлөгдөж ирсэн. Эхэндээ нисэх буудлуудын авто зогсоол энгийн, зохион байгуулалт багатай байсан бол өнөөдөр ухаалаг технологи, байгаль орчинд ээлтэй шийдлүүдийг тусгасан, зорчигчдын тав тух, аюулгүй байдлыг хангахуйц цогц систем болж хөгжсөөр иржээ.

Олон улсын нисэх онгоцны буудлын дэргэдэх авто машины зогсоолын зохион байгуулалт нь зорчигчдын тав тух, аюулгүй байдал, хөдөлгөөний урсгалын оновчтой зохицуулалтыг хангахуйц байх тодорхой шаардлагыг тавьдаг юм байна (Kováčiková et al., 2022).





МОНГОЛ УЛСЫН
ХАМГААЛТЫН
АЖИЛТНУУДЫН
ХЯНАЛТ

Олон улсын нисэх онгоцны буудлын дэргэдэх авто машины зогсоолд дараах үндсэн шаардлага тавигддаг юм байна. Үүнд:

1. Аюулгүй байдал

- Хяналтын систем – Камерын хяналт, хамгаалалтын ажилтнуудын хяналттай байх.

- Гэрэлтүүлэг – Шөнийн цагаар тод харагдахуйц гэрэлтүүлэгтэй байх.

- Галын аюулгүй байдал – Гал унтраах төхөөрөмж байрлуулж, яаралтай гарах гарцуудыг тодорхойлох.

- Явган зорчигчийн аюулгүй байдал – Явган хүний зам, гарц, дохио тэмдэглэгээг тодорхой болгох.

2. Авто машины хөдөлгөөний урсгалын оновчтой зохицуулалт

- Нэвтрэх, гарах бүсийг тодорхой болгох – Тасалбарын систем болон ухаалаг гарцуудтай байх.

- Нэг чигийн хөдөлгөөнийг дэмжих – Автомашинууд хоорондоо зөрчилдөхгүй, саадгүй зорчих чиглэлтэй байх.

- Такси, хувийн автомашин, нийтийн тээврийн бүсийг тусгаарлах – Тээврийн хэрэгслийн төрлөөс хамааран зогсоолын бүсүүдийг ялгах.

- Хурдан зогсох бүс (Drop-off & Pick-up zone) – Зорчигчдыг богино хугацаанд буулгах, суулгах зориулалттай бүсийг тусгайлан тодорхойлох.

3. Зогсоолын зохион байгуулалт ба хүртээмж

- Ойрын ба урт хугацааны зогсоол – Түр болон удаан хугацааны зогсоолыг ялгах.

- Тусгай хэрэгцээт иргэдийн зогсоол – Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай хэсэгтэй байх.

- Цахилгаан машин цэнэглэх станц – Ногоон эрчим хүчийг дэмжих зорилгоор цахилгаан машин цэнэглэх цэгүүдийг байгуулах.

- Захиалгат зогсоол – Онлайн захиалгатай урьдчилсан зогсоолын систем нэвтрүүлэх.

4. Дижитал болон ухаалаг технологийн шийдлүүд

- Автомат төлбөрийн систем – QR код, карт, гар утасны апп ашиглан төлбөр төлөх боломжтой байх.

- Мэдээллийн самбар, аппликейшн – Зорчигчдод зориулсан чөлөөтэй зогсоолын тоо, байршлыг заах дижитал самбарууд, апп хөгжүүлэх.

- Тээврийн хэрэгслийн тооллогын систем – Орох, гарах автомашины тоог хянах ухаалаг системтэй байх.

5. Байгаль орчин, зохистой төлөвлөлт

- Ногоон байгууламж – Агаарын бохирдлыг бууруулах, сэрүүцүүлэх үүднээс мод, ургамал тарих.

- Борооны ус зайлуулах систем – Ус зайлуулах сувгуудыг төлөвлөж, усанд автахаас сэргийлэх.

- Дуу чимээний бууралт – Дуу чимээний түвшнийг багасгахын тулд тусгаарлагч хаалт, зохион байгуулалтын шийдэл хэрэгжүүлэх.

6. Олон улсын стандарт, жишигт нийцсэн байдал

- ICAO (Олон улсын иргэний нисэхийн байгууллага), IATA (Олон улсын агаарын тээврийн холбоо)-ын стандарт шаардлагыг хангасан байх.

- Бусад улсын жишээг судалж, дэлхийн жишигт нийцсэн ухаалаг зогсоолын шийдлүүдийг нэвтрүүлэх (Civil Aviation Authority, 2016).

Дээр дурдсан олон улсад тавигддаг эдгээр шаардлагуудыг хангах замаар олон улсын нисэх онгоцны буудлын авто зогсоолын ашиглалтыг сайжруулж, зорчигчдод тав тухтай, найдвартай орчныг бүрдүүлэх боломжтой гэж дэлхийн улс орнуудын олон улсын нисэх буудлууд үздэг байна.



Дэлхийн улс орнуудын олон улсын нисэх онгоцны буудлын дэргэдэх авто машины зогсоолууд нь дараах төрлүүдтэй байдаг юм байна.

Авто машины зогсоолын төрлүүд -ийг зогсох хугацаа, байршил, хэрэглээний зориулалттай хүснэгтлэн авч үзье

Авто машины зогсоолын төрлүүд	Хугацаа:	Байршил	Хэрэглээ
Богино хугацааны зогсоол (Short-term Parking)	Ихэвчлэн 1-2 цаг хүртэл	Нисэх буудлын терминалын ойролцоо	Зорчигчдыг буулгаж, угтах Түр хугацаанд зорчигчид хүлээх Бизнес уулзалт, хурлын зориулалт
Урт хугацааны зогсоол (Long-term Parking)	Нэгээс олон хоног	Нисэх буудлаас хол байрладаг, автобус эсвэл шатлал үйлчилгээтэй	Зорчигчид урт хугацаагаар аялахаар явах үед машинаа үлдээх Нисэхийн ажилтнуудын байнгын ашиглах зогсоол
VIP ба бизнес зогсоол (Premium / VIP Parking)	Хязгааргүй, тусгай эрхтэй	Терминалын хамгийн ойролцоо	Тусгай эрхтэй зорчигчид (дипломат төлөөлөгчид, бизнес ангиллын зорчигчид, нисэхийн албаны хүмүүс) Тусгай үйлчилгээтэй машин (жишээ нь, лимузин, жолоочтой үйлчилгээ)
Түр хугацааны зогсоол (Cell Phone Lot)	Цагаар	Терминалаас бага зэрэг хол	Жолооч нар зорчигчдыг хүлээж, терминал руу орох шаардлагагүй байх Урт хугацааны зогсоолоос ялгаатай нь үнэгүй эсвэл бага төлбөртэй байх тохиолдол бий
Түрээсийн автомашины зогсоол (Rental Car Parking)	Хугацаагүй	Түрээсийн автомашины үйлчилгээний бүс	Машин түрээслэх болон буцааж өгөх зорилготой Ихэвчлэн тусдаа гарах, орох хэсэгтэй
Ажилчдын зогсоол (Employee Parking)	Хугацаагүй	Нисэх буудлын дотор эсвэл ойролцоо	Нисэх буудлын ажилчид, Онгоцны багийн гишүүд, Аюулгүй байдлын албаны ажилтнууд ашиглах

Хүснэгт 1. Автомашины зогсоолын төрөл

Манай улсын хувьд “Чингис Хаан” олон улсын нисэх буудал нь 2 талаасаа зэрэг онгоцнууд хөөрч буудаг байх салхины болон геологийн тооцоололттойгоор байгуулагдсан 2021 оны 7 дугаар сард нээлтээ хийн байгуулагдсан бөгөөд зурвасын хэмжээ - 3 600 м, терминалын талбай - 37 000 м/кв, цамхгийн өндөр - 41 м юм байна.

Нислэгийн хувьд олон улсын нисэх буудалд агаарын тээврийн үйлчилгээ үзүүлдэг MIAT/“МИАТ” ТӨХК, “AERO MONGOLIA/АЭРОМОНГОЛИА”

ХХК, “HUNNU AIR/ХҮННУ ЭЙР” ХХК, “EZNUS airways /ИЗИНИС ЭЙРВЭЙЗ” ХХК, “Mongolian Airways/МОНГОЛИАН ЭЙРВЕЙС КАРГО” ХХК зэрэг төрийн болон хувийн хэвшлийн компаниуд гадаад, дотоодын байнгын нислэг үйлдэж байна.

Дотоодын байнгын нислэг: Улаанбаатараас Ховд, Алтай, Улаангом, Өлгий, Мөрөн, Даланзадгад, Дорноговь зэрэг аймгийн төвүүд рүү байнгын нислэг болон Оюу Толгой нислэг үйлдэж байна.



МОНГОЛ УЛСЫН НИСЭХ ОНГОЦНЫ БУУДАЛ

Олон улсын байнгын нислэг:

Улаанбаатар хотоос Бээжин, Сөүл/Инчон, Бусан, Хонгконг, Станбул, Токио/Нарита, Праг, Эрхүү Улаан-Үд, Манжуур зэрэг улс, хотууд руу нийслэг үйлдэж байна (Чингис хаан олон улсын нисэх буудал, 2025).

“Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудал нь Монгол Улсын хамгийн том нисэх буудал бөгөөд жилээс жилд үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдэж байна. 2023 онд тус нисэх буудал нийт 1.7 сая зорчигч хүлээн авсан бол 2024 онд энэ тоо 2 саяд хүрч, шинэ дээд амжилт тогтоожээ (Олон улсын нислэгүүд, 2025).

Өдөр тутмын нислэгийн тоо, зорчигчдын тоог нарийвчлан авч үзвэл, 2023 оны 5-р сарын 1-нээс 9-р сарын 1-ний хооронд олон улсын чиглэлд 587,061, орон нутгийн чиглэлд 157,070 зорчигч хүлээн авсан байна. Энэ хугацаанд хамгийн их ачаалалтай сар нь 8-р сар байсан бөгөөд зөвхөн энэ сард 232,713 зорчигч үйлчлүүлжээ. Түүнчлэн, 8-р сарын 12-нд нэг өдөрт 9,085 зорчигч хүлээн авсан нь хамгийн өндөр үзүүлэлт байв. Эдгээр тоон үзүүлэлтүүдээс харахад, “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудал өдөрт дунджаар 5,000-6,000 орчим зорчигч хүлээн авдаг хэдий ч, зуны улирал зэрэг ачаалал ихтэй үед энэ тоо нэмэгдэж, өдөрт 8,000-9,000 зорчигч хүрэх тохиолдол байдаг юм байна.

Нислэгийн тооны хувьд, 2022 онд тус нисэх буудал олон улсын чиглэлд 5,211 нислэг, орон нутгийн чиглэлд 4,288 нислэг үйлдсэн байна. Энэ нь нийт 9,499 нислэг болж байгаа бөгөөд өдөрт дунджаар 26 нислэг үйлдэгдсэн гэсэн үг юм (Зам, тээврийн салбарын 7

хоногийн статистик мэдээ, 2025). Эдгээр мэдээллээс үзэхэд, “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудал өдөрт дунджаар 26 нислэг хүлээн авч, 5,000-6,000 орчим зорчигчдод үйлчилдэг байна. Ачаалал ихтэй үед энэ тоо нэмэгдэж, өдөрт 8,000-9,000 зорчигч хүрэх боломжтой байдаг юм байна.

Нисэх буудлаар үйлчлүүлж байгаа үйлчлүүлэгчдийн талаарх тоо мэдээний эх сурвалж нь “Чингис хаан” олон улсын нисэх буудлын албан ёсны цахим сайтаас нь авсан тоо мэдээ учир нэвтэрсэн тээврийн хэрэгслийн талаарх тоо мэдээ баттай гэж үзэж байна.

Замын хөдөлгөөний ачааллын судалгаа:

“Чингис хаан” олон улсын нисэх буудлаар үйлчлүүлж байгаа тээврийн хэрэгслийн тоог 2024 оны 4 сараас өмнө гаргаж байгаагүй бөгөөд 2024 оны 04 дүгээр сарын 30-ний өдрөөс эхлэн авто машины зогсоолын мөнгө хураадаг цэг ашиглалт орсноор тээврийн хэрэгслийн тоог нарийвчлан гаргах боломжтой болсон юм.

Монгол, Японы хамтарсан “Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт” компанийн Тээвэр зохицуулалтын хэлтэс хариуцан хэрэгжүүлдэг юм байна.

Монгол, Японы хамтарсан “Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт” компани нь “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх концессын гэрээг Монгол Улсын Засгийн газартай байгуулан, 2019 оны 07 дугаар сараас үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн компани юм байна.

№	Он, сар	Орсон тээврийн хэрэгсэл	Гарсан тээврийн хэрэгсэл
		Тоо	Тоо

1.	2024.05	51839	54247
2.	2024.06	61687	62877
3.	2024.07	75261	71790
4.	2024.08	87643	78937
5.	2024.09	65159	59737
6.	2024.10	49352	43976
7.	2024.11	47076	43162
8.	2024.12	49743	46712
9.	2025.01	55873	51249
10.	2025.02	46808	43267
11.	2025.03	47692	44921
Нийт		638133	600875

Хүснэгт 2. Нэвтэрсэн тээврийн хэрэгслийн тоо

“Чингис хаан” олон улсын нисэх буудлын авто машины зогсоолын мөнгө хураах цэгийн үйл ажиллагаа 2024 оны 5 сараас эхэлснээс хойших нийт 11 сарын хугацаанд /2024.05-2025.03/ нийтдээ 638133 тээврийн хэрэгсэл нэвтэрч, 60875 тээврийн хэрэгсэл гарсан гэсэн статистик тоо мэдээ байна.

Нисэх буудлаар орж гарсан тээврийн хэрэгслийн зөрүү 37258 тээврийн хэрэгсэл нь “Чингис хаан” олон улсын нисэх буудлын менежментийг хариуцдаг “Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт” компанийн тээврийн хэрэгсэл бөгөөд зогсоолын мөнгө хураах цэгээр гарахдаа үнэ төлбөргүй шууд гардгаас зөрүүтэй тоо гардаг юм байна.

“Чингис хаан” олон улсын нисэх буудлын авто машины зогсоолоор 1 сард дунджаар 58012, 1 өдөрт дунджаар 1933 тээврийн хэрэгсэл орж гарч байдаг нь “Нью Улаанбаатар Интернэйшнл Эйрпорт” компанийн үйл ажиллагааны тайлан мэдээнээс харагдаж байгаа бөгөөд энэ нь замын хөдөлгөөний ачаалал болон зам тээврийн осол, зөрчил гарахад тодорхой нөлөө үзүүлэх хүчин зүйл болдог юм болдог байна.

Зам тээврийн ослын нөхцөл байдал:

“Чингис хаан” олон улсын нисэх буудлын ойр орчим болон авто машины зогсоолын талбайд гарсан зам тээврийн осол, зөрчлийн судалгааг сүүлийн 3 жилээр нь авч үзвэл:

№	Он	Нийт ослын дуудлага, мэдээлэл	Зам тээврийн ослын дуудлага, мэдээлэл			
			Нисэх буудлын ойр орчимд		Автомашинны зогсоолд болсон осол	
1.	2022 он	9	5	55.5%	4	44.5%
2.	2023 он	23	9	39.2%	14	60.8%
3.	2024 - 2025 оны 3 сар хүртэл	16	10	62.5%	6	37.5%
Нийт		48	24	50%	24	50%

Хүснэгт 3. Зам тээврийн ослын судалгаа (Иргэний агаарын тээврийн Цагдаагийн хэлтэс, 2024).



МОНГОЛЫН
ДӨРӨН
УЛСЫН
ПОЛИЦИЯ
АКАДЕМИ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ САХИУЛАХУЙ

Дээрх хүснэгтээс үзвэл сүүлийн 3 жилийн байдлаар “Чингис хаан” олон улсын нисэх буудлын хамаарах нутаг дэвсгэрт нийтдээ 48 зам тээврийн ослын дуудлага, мэдээлэл ирснээс 24 буюу 50% нь нисэх буудлын хамаарах нутаг дэвсгэрийн замын хөдөлгөөнд гарсан бол үлдсэн 24 буюу 50% нь нисэх буудлын авто машины зогсоолд гарсан байна.

“Чингис хаан” олон улсын нисэх буудлын хамаарах нутаг дэвсгэрт гарч байгаа зам тээврийн осол, зөрчлийн 50% нь авто машины зогсоол дээр гарч байгаа нь тулгамдсан асуудал болжээ.

Фокус ярилцлага: Бид судалгааны ажлаа хийхийн өмнө “Улаанбаатар такси трансфорт сервис” ХХК, “Вип такси сервис” ХХК-нд таксины жолоочоор ажилладаг 4 иргэн, хувиараа такси үйлчилгээ эрхэлж байгаа 3 иргэнтэй хамт нисэх буудлын зогсоолын орчимд цугларч фокус ярилцлага хийж, түүний үр дүнд үндэслэн энэхүү судалгааг хийхээр шийдвэрлэсэн билээ.

Ярилцлагад оролцсон жолооч иргэд анх нисэх буудлын авто машины зогсоол руу орж ирэхдээ их будилж, тойрч, хүнээс асууж байж зогсоол руу тойрч ордог болохыг мэдсэн. Хэдийгээр тэмдэг тэмдэглэгээ байсан хэдий ч ихэнх жолооч нар анзаардаггүй, шууд орчхоод гайхаад байдаг гэсэн нь бид энэхүү судалгааг хийх шаардлага байгааг олж харсан юм.

Иргэний агаарын тээврийн цагдаагийн хэлтсийн нийт 28 алба хаагчдыг түүврийн аргаар сонгон авч судалгааны хамрах хүрээгээ тодорхойлсон бөгөөд анкет асуулгын аргаар судалгаа авч, шинжилгээ хийв.

Судалгаанд оролцогчдын товч анкет: Судалгаанд оролцогчдын насны байдлыг авч үзвэл 4 буюу 14.3% нь “18-25”, 4 буюу 14.3% нь “26-29”, 7 буюу 25% нь “30-34”, 7 буюу 25% нь “35-39”,

5 буюу 17.9% нь “40-44”, 1 буюу 3.6% нь “44-49” насны алба хаагчид байсан бөгөөд хүйсийн хувьд 2 буюу 3.6% нь “эмэгтэй”, 26 буюу 96.4% нь “эрэгтэй” алба хаагчид хамрагдав.

Судалгаанд оролцогчдын боловсролын байдлыг авч үзвэл 19 буюу 67.9% нь “дээд”, 4 буюу 14.3% нь “тусгай дунд”, 5 буюу 17.9% нь “бүрэн дунд” боловсролтой алба хаагчид байсан бөгөөд ажилласан жил, туршлагыг нь харвал, 1 буюу 3.6% нь “1 хүртэлх жил”, 7 буюу 25% нь “1-3 жил”, 7 буюу 25% нь “4-6 жил”, 5 буюу 17.9% нь “7-10 жил”, 6 буюу 21.4% нь “11-15 жил”, 2 буюу 7.1% нь “16-20 жил” ажилласан туршлагатай алба хаагчид оролцов.

Судалгаанд оролцогчдын албан тушаалын байдлыг авч үзвэл 7 буюу 25% нь “зохицуулагч”, 3 буюу 10.7% нь “цагдаа-зохицуулагч”, 11 буюу 39.3% нь “хэв журмын цагдаа”, 2 буюу 7.1% нь “хэв журмын байцаагч”, 3 буюу 10.7% нь “ахлах байцаагч”, 2 буюу 7.1% нь “тасгийн дарга” албан тушаалтай алба хаагчид байв.

Үндсэн судалгааны хэсэг. Манай улсад үйл ажиллагаа явуулдаг “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудлын замын хөдөлгөөний зохион байгуулалт нь ямар улсын загвараар бүтээгдсэн болох талаар судалгаанд оролцсон цагдаагийн алба хаагчдаас асууж тодруулахад 5 буюу 18% нь “Монгол Улс”, 20 буюу 71% нь “Япон улс”, 3 буюу 11% нь “мэдэхгүй” гэсэн хариултыг өгсөн байна. Харин “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудлын гадна авто машины зогсоолд өдөрт дунджаар хэдэн машин байрлаж үйлчлүүлдэг вэ?” гэсэн асуултад 2 буюу 7% нь “200-400”, 2 буюу 7% нь “401-500”, 1 буюу 4% нь “501-600”, 5 буюу 18% нь “601-700”, 5 буюу 18% нь “701-800”, 13 ба 46% нь

“801 ба түүнээс дээш” тооны авто машин зогсоолоор үйлчлүүлдэг гэжээ.



Зураг 1. Зохион байгуулалтын загвар

Дээрх Зурагуудаас үзвэл судалгаанд оролцсон цагдаагийн алба хаагчдын дийлэнх буюу 70 гаруй хувь нь Япон улсын нисэх буудлын дэргэдэх автомашины зогсоолын зохион байгуулалтаар хийгдсэн гэж үзэж байгаа бөгөөд энэ нь манай улсын Замын хөдөлгөөний дүрэмтэй зөрчилдөх магадлалтай байж болохыг харж болохоор байна. /Зураг №1/ Харин “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудлын дэргэдэх авто машины зогсоолд өдөрт дунджаар 800 ба түүнээс дээш тооны авто машин байрлаж үйлчлүүлдэг гэсэн нь замын хөдөлгөөний ачаалал өндөр байгааг илэрхийлэх дүн гэж үзэж байна. Энэ нь “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудлын бүсэд замын хөдөлгөөний урсгал ихтэй, ачаалалтай байгаа нь замын цагдаагийн алба хаагчдын ажлын ачааллыг тооцох нэг хүчин зүйл гэж үзэв.

“Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудлын орчимд замын хөдөлгөөний дүрэм зөрчих явдал хэр их гардаг вэ?” гэсэн асуултад 2 буюу 7% нь “Маш их”, 8 буюу 29% нь “Их”, 14 буюу 50% нь “Дунд зэрэг”, 3 буюу 11% нь “Бага”, 1 буюу 3% нь “Гардаггүй” гэсэн хариултыг өгчээ. Харин “Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудлын орчимд замын тээврийн осол,

зөрчил хэр их гардаг вэ?” гэсэн асуултад 2 буюу 7% нь “Маш их”, 2 буюу 7% нь “Их”, 14 буюу 50% нь “Дунд”, 10 буюу 36% нь “Бага” гэсэн хариултыг өгчээ.

Судалгаанд оролцогчдын өгсөн хариултаас үзвэл “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудлын орчимд замын хөдөлгөөний дүрэм зөрчих явдал их гардаг гэж байгаа нь нисэх буудлаар үйлчлүүлж байгаа тээврийн хэрэгслийн тоо их, гадаад, дотоодын нислэгээр олон иргэд үйлчлүүлж байгаа, нөгөө талаараа Япон улсын нисэх буудлын загвараар зогсоолын зохион байгуулалт, загвартай байгаа нь холбоотой гэж үзэв. /Зураг №3/ Түүнчлэн нисэх буудлын орчимд зам тээврийн осол их биш ч багагүй гарч байгаа нь авто машины тоо, буудлын дэргэдэх зогсоолын зохион байгуулалтыг жолооч иргэд төдийлөн сайн мэдэхгүй байгаатай холбоотой гэж үзэж болохоор байна. /хавсралт Зураг №4/

Судалгаанд оролцогчид “Нисэх онгоцны буудлын бүсийн орчимд авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж байгаа замын цагдаагийн алба хаагчид хэр их ажлын ачаалалтай ажилладаг вэ?” гэсэн асуултад 14 буюу 50% нь “Их”, 9 буюу 32% нь “Дунд”, 4 буюу 14% нь “Бага”, 1 буюу 4% нь





ᠮᠣᠩᠭᠣᠯᠤ ᠰᠤᠬᠢᠭᠣᠯᠠᠬᠤᠢ

“Ачаалалгүй” гэж хариулжээ. Харин “Жолооч нар Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудлын гадна байдаг авто замын хөдөлгөөний урсгал,



Зураг 2. Замын цагдаагийн ачаалал

Судалгаанд оролцогчдын өгсөн дээрх хариултаас “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудал өдөрт дунджаар 5,000-6,000 зорчигч, тэднийг гаргаж өгөх, тосож авах иргэдийн тоо нэмэгдвэл өдөрт дунджаар 7,000-8,000 иргэн үйлчлүүлдэг, мөн зорчигчдын нисэх буудал руу ирэхдээ ашиглаж байгаа тээврийн хэрэгслийн тоог бодож үзвэл судалгаанд оролцогчдын ажлын ачаалал өндөр байгаа нь харагдаж байна. /Зураг 2/ Харин Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудлын дэргэдэх авто машины зогсоол руу чиглэсэн замын хөдөлгөөний урсгал, чиглэл, зохион байгуулалтыг мэдэхгүйгээс андуурч хөдөлгөөнд оролцдог явдал их байгаа нь судалгаанд оролцогчдын хариултаас харагдаж байна. /Зураг 3/ Энэ нь судалгаанд оролцсон цагдаагийн алба хаагчдын өгсөн хариултаар нотлогдож байна.

“Чингис хаан” олон улсын нисэх буудлын орчмын замын хөдөлгөөний урсгал, чиглэл, зохион байгуулалтыг заасан тэмдэг, тэмдэглэгээ хэр их тавигдсан байдаг вэ?” гэсэн асуултад

чиглэл, зохион байгуулалтыг хэр их андуурч хөдөлгөөнд оролцдог вэ?” гэсэн асуултад 12 буюу 43% нь “Их”, 11 буюу 39% нь “Дунд зэрэг”, 5 буюу 18% нь “Бага” гэсэн хариултыг өгсөн байна.



Зураг 3. Замын хөдөлгөөний зохицуулалт

судалгаанд оролцогчдын 85 орчим хувь нь их тавигдсан /хавсралт Зураг №7/ гэж үзсэн бол уг тэмдэг тэмдэглэгээ жолооч нарт хэр их ойлгомжтой байдаг талаар тодруулахад 12 буюу 43% нь “ойлгомжтой”, 12 буюу 43% нь “дунд зэрэг”, 1 буюу 3% нь “бага”, 3 буюу 11% нь “ойлгомжгүй” гэсэн хариултыг тус тус өгчээ. /хавсралт Зураг №8/ Дээрх хариултуудаас үзвэл нисэх буудлын бүсэд замын тэмдэг, тэмдэглэгээ зохих хэмжээнд тавигдсан хэдий ч жолооч нарын мэдлэг дутмаг, зарим талаараа жолооч нарын хайхрамжгүй, хэнэггүй байдлаас улбаатайгаар зөрчил гаргах явдал түгээмэл байдаг нь харагдаж байна.

“Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудлын орчмын авто замын хөдөлгөөний зохион байгуулалтыг заасан тэмдэг, тэмдэглэгээг жолооч нар хэр их андуурдаг вэ? гэсэн асуултад 8 буюу 29% нь “их”, 11 буюу 39% нь “дунд зэрэг”, 9 буюу 32% нь “бага” гэсэн хариултыг өгчээ. Харин “Хөшигтийн хөндийн Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудлын

орчин дахь авто машины замын хөдөлгөөний урсгал, чиглэлийг өөрчлөх хэрэгцээ шаардлага байна уу?”



Зураг 4. Замын тэмдэг андуурах байдал

гэсэн асуултад 8 буюу 28% нь “тийм”, 8 буюу 28% нь “үгүй”, 12 буюу 43% нь “зарим хэсгийг” гэсэн хариултыг өгчээ.



Зураг 5. Зогсоолын зохион байгуулалт өөрчлөх хэрэгцээ шаардлага

Судалгаанд оролцсон алба хаагчдын өгсөн хариултаас үзвэл “Чингис хаан” олон улсын нисэх буудлын бүс дэх замын зохион байгуулалт, замын урсгал, чиглэлийг жолооч нар мэдэхгүй андуурах, будилах явдал түгээмэл гарч, замын хөдөлгөөний дүрэм зөрчих явдал их байдаг нь харагдаж байна. /Зураг 4/ Түүнчлэн Иргэний агаарын тээврийн цагдаагийн хэлтсийн алба хаагчдын 20 буюу 71% нь нисэх буудлын бүс дэх замын хөдөлгөөний зохион байгуулалт, урсгал чиглэлд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзсэн нь энэхүү судалгааны ажлын үр дүн ач холбогдолтой болсныг харуулж байна.

“Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудлын зогсоол болон бусад орчинд замын хөдөлгөөний дүрмийн зөрчил гарахад юу хамгийн их нөлөөлдөг вэ? гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 3 буюу 10.7% нь “замын тэмдэг, тэмдэглэгээ ойлгомжгүй”, 2 буюу 7.1% нь “Замын тэмдэг, тэмдэглэгээ бага тавигдсан”, 9 буюу 32.1% нь “Гадаад улсын замын


хөдөлгөөний зохион байгуулалтаар нисэх буудлын бүс дэх замын хөдөлгөөн зохицуулалт хийгдэж байгаа учраас жолооч нар замын хөдөлгөөний урсгал, чиглэлээ мэдэхгүй, андуурч будилдаг байдал”, 12 буюу 42.9% нь “манай жолооч нарын замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг хангалтгүй, бас хэнэггүй байдал”, 1 буюу 3.6% нь “нисэх буудлын бүсэд нэг дор автомашины бөөгнөрөл их, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний урсгал их байдаг”, 1 буюу 3.6% нь “бусад” гэсэн нөлөөллийн хүчин зүйлүүдийг дурджээ. /Зураг 6/

Дээрх асуултын хариултуудыг нэгтгэн авч үзвэл манай жолооч нарын дунд нийтлэг түгээмэл байдаг замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг сул, замын тэмдэг, тэмдэглэгээ сайн мэддэггүй байдаг нөлөөлж байгаа бол нөгөө талаас Япон улсын замын хөдөлгөөний зохион байгуулалтаар зогсоолын хэсэг зохицуулагдаж байгаа нь зөрчил гарахад хамгийн ихээр нөлөөлж байна гэж үзэв.





ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠰᠤᠬᠢᠭᠣᠯᠠᠬᠤᠢ




Зураг 6. Замын хөдөлгөөний дүрэм зөрчихөд нөлөөлж буй хүчин зүйл

“Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудлын зогсоол болон бусад орчинд замын хөдөлгөөний дүрмийн зөрчил гарахад нөлөөлдөг сөрөг хүчин зүйлүүдийг бууруулах, зөрчил гарах бусад нөхцөл байдлуудыг арилгах чиглэлээр Иргэний агаарын тээврийн цагдаагийн хэлтэс дангаараа бус харин Замын цагдаагийн газар болон нисэх буудлын удирдлагатай хамтран тодорхой ажил, арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлбэл үр дүнд хүрэх болно.

Судалгаанд оролцсон цагдаагийн алба хаагчдаас “Чингис хаан” олон улсын нисэх буудлын захиргаатай авто машины замын хөдөлгөөний урсгал,


чиглэлт, зохион байгуулалттай холбоотойгоор танай цагдаагийн хэлтсийн удирдлагаас санал бодлоо хэлж, уулзаж байсан уу?” гэсэн асуултад 16 буюу 57% нь “Тийм”, 6 буюу 22% нь “үгүй”, 6 буюу 21% нь “мэдэхгүй” гэсэн хариултыг өгчээ. Түүнчлэн “Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудлын гаднах авто машины зогсоол руу тойрог чиглэлээр явж ордог зохион байгуулалтын хэлбэр хэр их оновчтой гэж та үзэж байна вэ?” гэсэн асуултад 9 буюу 32% нь “оновчтой”, 13 буюу 47% нь “оновчгүй”, 6 буюу 21% нь “Мэдэхгүй” гэсэн хариултыг өгчээ.

Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудлын захиргаатай авто машины замын хөдөлгөөний урсгал, чиглэлт, зохион байгуулалттай холбоотойгоор танай цагдаагийн хэлтсийн удирдлагаас санал бодлоо хэлж, уулзаж байсан уу?



Зураг 7. Зохион байгуулалтын өөрчлөх санал

Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудлын гаднах авто машины зогсоол руу тойрог чиглэлээр явж ордог зохион байгуулалтын хэлбэр хэр их оновчтой гэж та үзэж байна вэ?



Зураг 8. Зогсоолын оновчтой байдал

Судалгаанд оролцсон цагдаагийн алба хаагчдын үзэж байгаагаар нисэх буудлын дэргэдэх авто машины зогсоолын зохион байгуулалт, замын хөдөлгөөний урсгал чиглэлтэй холбоотой санал хүсэлтээ нисэх буудлын захиргаанд удаа дараа гаргаж байсан ч хөрөнгө мөнгө байхгүй гэсэн шалтгаанаар хүлээн авдаггүй, ажил, арга хэмжээ авч хэрэгжүүлдэггүй нь Иргэний агаарын тээврийн цагдаагийн хэлтэс, Нисэх буудлын захиргаатай хамтын ажиллагаа төдийлөн хангалттай хэмжээнд ажиллаж чадахгүй байгаа, нөгөө талаараа зогсоолын ач холбогдлыг төдийлөн үнэлэхгүй байгаа юм байна гэж үзэхэд хүргэж байна.

Мөн “Чингис хаан” нисэх буудлын дэргэдэх авто машины зогсоол руу шууд бус, харин тойрог чиглэлээр тойрч явсны дараа зүүн хойд талаасаа ордог зохион байгуулалтын хэлбэрийг 47% нь оновчгүй гэж үзсэн замын хөдөлгөөний чиглэлийг өөрчилж, шууд зогсоол руу ордог болох шаардлага байгааг харж болохоор байна.

Судалгаанд оролцсон Иргэний агаарын тээврийн цагдаагийн хэлтсийн алба хаагчдын нисэх буудлын дэргэдэх авто машины зогсоол, санаа бодол, гаргасан саналыг нэгтгэн авч үзвэл:

- Жолооч нарын замын хөдөлгөөнд дүрэм баримтлан оролцох талаар самбар байршуулах;

- Баруун туннелийн зорчих хэсгийг өөрчлөх;

- Автомашины зогсоол руу шууд ордог болгох;

- Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэмд нийцүүлэн өөрчлөлт хийх;

- Замын хөдөлгөөний урсгал, чиглэлийг энгийн жолооч нарт хялбар ойлгогддог байхаар өөрчлөх;

- Тууш замаас шууд зогсоол руу ордог болгох;

- Замын тэмдэг, тэмдэглэгээг бага байгааг анхаарч нэмэгдүүлэх;

- Авто машины зогсоолын хүчин чадлыг нэмэгдүүлэх;

- Хурд сааруулагчийг оновчтой газруудад байршуулах, тухайлбал баруун аркийн хойноос орох хэсэгт;

- Чиглэл заасан тэмдэг, тэмдэглэгээг тодорхой газруудад оновчтой байдлаар байршуулах зэрэг саналуудыг дэвшүүлсэн байна.

Дээрх саналуудыг нэгтгэн авч үзвэл Нисэх буудлын захиргаа, Иргэний агаарын тээврийн цагдаагийн хэлтсийн хамтын ажиллагаа, түүний хэрэгжилт хангалттай бус байгааг илэрхийлж байгаа бөгөөд цаашид



МОНГОЛ УЛСЫН
ПОЛИЦИЯН
АКАДЕМИ



ᠮᠤᠩᠭᠣᠯᠤ ᠰᠤᠬᠢᠭᠣᠯᠠᠬᠤ

зогсоолын зохион байгуулалт, замын хөдөлгөөний урсгал, чиглэлийг өөрчлөн сайжруулах хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна.

Судалгааны ажлыг бататгах үүднээс нисэх буудлын замын хөдөлгөөний аюулгүй байдалд хяналт тавьдаг замын цагдаагийн 5 алба хаагчидтай фокус ярилцлага хийхэд анкет асуулгын аргаар хийсэн судалгааны дүн бодитой гарч байна гэж үзэхэд хүрч байна.

Дүгнэлт

“Чингис Хаан” олон улсын нисэх буудлын дэргэдэх авто машины зогсоолын зохион байгуулалт, түүний хэрэгжилт, нисэх буудлын бүсэд гардаг зөрчил, гарахад нөлөөлж буй хүчин зүйл, зогсоолын зохион байгуулалтыг өөрчлөх хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, сайжруулах арга замыг эрэлхийлэх зорилгоор хийсэн судалгааны үр дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Олон улсын нисэх онгоцны буудлын авто машины зогсоол нь нисэх буудлаар үйлчлүүлж буй зорчигчдын тав тухтай үйлчлүүлэх, нисэх буудлын ажилтнуудын, түүнчлэн үйлчилгээний машинуудыг байрлуулах зориулалттай, Япон улсын нисэх буудлын зохион байгуулалтын загвараар бүтээгдсэн тусгай бүс юм байна.

2. “Чингис Хаан” олон улсын нисэх буудлын дэргэдэх авто машины зогсоолын зохион байгуулалт, замын хөдөлгөөний урсгал, чиглэл нь Япон улсын замын зохион байгуулалтын загвараар хийгдсэн байх бөгөөд энэ нь жолооч нарын Замын хөдөлгөөний дүрэм зөрчих нэг хүчин зүйл болдог байна.

3. “Чингис Хаан” олон улсын нисэх буудлын бүсэд зам тээврийн осол, зөрчил цөөнгүй гардаг нь 1 сард дунджаар 58012, 1 өдөрт дунджаар 1933 тээврийн хэрэгсэл орж гарч

үйлчлүүлж байдаг хөдөлгөөний ачааллаас үүдэлтэй, нөгөө талаараа гадаадын замын хөдөлгөөний зохион байгуулалтын загвараар хийгдсэн, шулуун замаар тойрог байдлаар зогсоол руу ордог зохион байгуулалтын хэлбэр, замын хөдөлгөөний чиглэл заасан тэмдэг, тэмдэглэгээ хангалтгүй байршуулсан, жолооч нарын Замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг сул, хэнэггүй байдлаар хөдөлгөөнд оролцдог зэрэг олон хүчин зүйл нөлөөлдөг байна.

4. Иргэний агаарын тээврийн цагдаагийн хэлтэс, нисэх буудлын захиргааны хамтын ажиллагааны хэрэгжилт хангалтгүй байгаа нь хэлтсээс нисэх буудлын зогсоол, замын хөдөлгөөний урсгал, чиглэл, зохион байгуулалттай холбоотойгоор өгсөн санал, хүсэлт, түүний мөрөөр хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ бага байгаа нь судалгаанд оролцсон алба хаагчдын өгсөн хариултаас тодорхойлогдож байна.

5. “Чингис Хаан” олон улсын нисэх буудлын авто машины зогсоолын зохион байгуулалт, замын хөдөлгөөний урсгал, чиглэлээс үүдэлтэй зөрчил, түүнд нөлөөлж буй хүчин зүйл, тээврийн хэрэгслийн тоо, түүнчлэн судалгаанд оролцсон алба хаагчдаас гаргасан санал, хүсэлт зэргийг харгалзан зогсоолын зохион байгуулалт, замын хөдөлгөөний урсгал, чиглэлийн зарим хэсгийг өөрчлөх хэрэгцээ шаардлага байна гэсэн дүгнэлтийг өгч байна.

6. Энэхүү судалгааны ажлыг хийснээр “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудлын дэргэдэх авто машины зогсоолын хүчин чадал нэмэгдэх, зохион байгуулалтад өөрчлөлт оруулах, дэвшилтэд техник технологи нэвтрүүлэх ажлыг хэрэгжүүлж чадвал замын хөдөлгөөний дүрэм зөрчих явдал буурч, зорчигч

иргэдийн амар тайван, аюулгүй орчинд үйлчлүүлэх боломж нөхцөл нэмэгдэх ач холбогдолтой болох юм.

Санал

Дээрх дүгнэлт, судалгааны үр дүн, алба хаагчдын дэвшүүлсэн санал, хүсэлтийг үндэслэсэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. “Чингис Хаан” олон улсын нисэх буудлын баруун тунелийн зорчих хэсгийн зохион байгуулалтыг өөрчлөх;

2. “Чингис Хаан” олон улсын нисэх буудал очих тууш замаас авто машины зогсоол руу шууд ордог болгох зохион байгуулалтыг хийх;

3. Тууш замаас шууд зогсоол руу ордог чиглэл заасан замын тэмдэг, тэмдэглэгээний тоог нэмэгдүүлж, жолооч нарт дүрэм зөрчихгүй байх боломж, нөхцөлийг нэмэгдүүлэх;

4. Нисэх буудлын авто машины зогсоолын хүчин чадлыг нэмэгдүүлэх;

5. Нисэх буудлын бүс дэх замын хурд сааруулагчийг оновчтой газруудад байршуулах /тухайлбал баруун аркийн хойноос орох хэсэгт/ зэрэг саналуудыг дэвшүүлээ.

Ашигласан материал

Chapter 17.27: PARKING STANDARDS AND REQUIREMENTS. (2025, 01 07). Retrieved from City of Mill Creek, WA: <https://www.codepublishing.com/WA/MillCreek/html/MillCreek17/MillCreek1727.html>

“Чингис хаан” олон улсын нисэх буудлын нээлтийн ёслол. (2021). Япон улсын элчин сайдын яам: https://www.mn.emb-japan.go.jp/itpr_ja/internationalairp

ort0704mon.html?utm_source=ээс Гаргасан

Civil Aviation Authority. (2016). SUBMISSION ON BEHALF OF THE INDEPENDENT AIRPORT PARKING ASSOCIATION (IAPA). UK.

Kováčiková, K., Novák, A., Kováčiková, M., & Sedláčková, A. (2022). Smart parking as a part of Smart airport concept. *Transportation Research Procedia*, 65, 70-77. <https://doi.org/https://doi.org/10.1016/j.trpro.2022.11.009>

Бүртгэгдсэн зам, тээврийн осол, бүс, аймаг, нийслэлээр. (2022-2025). Статистикийн мэдээллийн нэгдсэн сан: https://www2.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_2300_039V1 -ээс Гаргасан

Зам, тээврийн салбарын 7 хоногийн статистик мэдээ. (2025 оны 04 07). Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК: <https://khkhap.mn/content/show/id/489>-ээс Гаргасан

Иргэний агаарын тээврийн Цагдаагийн хэлтэс. (2024). 2022-2024 оны тайлан.

Олон улсын нислэгүүд. (2025). Чингис хаан олон улсын нисэх буудал: <https://www.ulaanbaatar-airport.mn/international-flights>-ээс Гаргасан

Чингис хаан олон улсын нисэх буудал. (2025). Дотоодын агаарын тээвэрлэгчид: <https://www.ulaanbaatar-airport.mn/air-carriers>-ээс Гаргасан




МОНГОЛЫН ШТДН-ЫН АКАДЕМИ




МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗӨРЧЛӨЛ



Зураг 9. ЗХД-ийн зөрчил



Зураг 10. Зам тээврийн осол



Зураг 7. Замын тэмдэг тэмдэглэгээ



Зураг 8. Замын хөдөлгөөний зохицуулалт